



МОНГОЛ УЛС  
БАЯНХОНГОР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2021 оны 11 сарын 10 өдөр

Дугаар А/691

Номгон

Галт зэвсгийн үзлэг, тооллого, татвар  
хураалтын ажлыг эрчимжүүлэх тухай

Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.1.е, 29.1.6. "а" дахь заалт, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Аймгийн хэмжээнд галт зэвсгийн үзлэг, тооллого, татвар хураалтын ажлыг 2021 оны 11 дүгээр сарын 08-ны өдрөөс 12 дугаар сарын 16-ны өдрийг хүртэлх хугацаанд зохион байгуулсугай.


2.Галт зэвсгийн тухай хууль тогтоомжийг иргэдэд сурталчлах, галт зэвсгийн бүртгэл, тооллогын ажлыг зохион байгуулж, бүртгэлгүй нуугдмал галт зэвсгийг олж илрүүлэх, бүртгэлд хамруулж гэрчилгээжүүлэх, галт зэвсгийн нэгдсэн бүртгэлд тодотгол хийх, хууль зөрчсөн иргэдэд хариуцлага тооцож ажиллахыг Цагдаагийн газрын дарга, (Цагдаагийн хурандаа Б.Оюутболд)-д Галт зэвсгийн албан татварын хуулийг сурталчлах, бүртгэл судалгаанд тодотгол хийх, татварын орлогын бүрдүүлэлт, хураалтын ажлыг эрчимжүүлж ажиллахыг аймгийн Татварын хэлтсийн дарга (С.Рэнцэндагва)-д тус тус үүрэг болгосугай.

3.Орон нутгийн төсөвт галт зэвсгийн албан татварыг төвлөрүүлэх, аймгийн Цагдаагийн газраас зохион байгуулж байгаа галт зэвсгийн үзлэг тооллогын ажилд дэмжлэг үзүүлэх үүрэг бүхий ажлын хэсгийг байгуулж, ажлын үр дүнг нь тооцож ажиллахыг сумдын Засаг дарга нарт тус тус үүрэг болгосугай.

4.Галт зэвсгийн үзлэг тооллогыг явуулах, галт зэвсгийн албан татвар хураалтын ажлыг аймгийн хэмжээнд зохион байгуулахтай холбогдон гарах нийт 1.500.000 /Нэг сая таван зуун мянган/ төгрөгийг холбогдох зардлаас гаргахыг Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга (С.Байгалмаа)-д зөвшөөрсүгэй.

5.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Тамгын газрын даргын албан үүргийн түр орлон гүйцэтгэгч (Д.Энхжаргал)-д даалгасугай.

ДАРГА



Д.МӨНХСАЙХАН

601210617